



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/59

Бодь

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд
мод тарих ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, Ойн тухай хуулийн 31.2, Газрын тухай хуулийн 56.6, Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.4, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 63,58 дугаар зарлиг, аймгийн Засаг даргын 2022 оны А/341 дүгээр захирамж, сумын Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1, 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд бүх нийтээр мод тарих аяныг сумын хэмжээнд өрнүүлж 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Бүх нийтээр мод тарих аяныг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, мод тарих хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Мод тарих албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг орон нутагт дасан зохицох, стандартын тарьц суулгац, мод тарьж ургуулах арчлан хамгаалахтай холбоотой шинэ дэвшилтэт технологийг сурталчлах зэрэг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (С.Ганцэцэг), Байгаль хамгаалагч (П.Батбаатар), (Н.Жаргалсайхан) нарт үүрэг болгосугай.

4.Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд бүх нийтээр мод тарих 2022 оны хавар, намрын улиралд мод тарих ажилд идэвх санаачилагатай оролцохыг албан байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэдэд уриалсугай.

5.Мод тарих талбай сонгох, хөрс боловсруулах, тарьц суулгацаар хангах, тарьсан модыг услах, арчлах, ажлыг зохион байгуулж холбогдох санхүүжилтыг бүрэн шийдвэрлэж ажиллахыг албан байгууллагын дарга, эрхлэгч, аж ахуйн


642201109

нэгжийн захирал, дэлгүүр хоршооны эзэдүүд, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6.Аяны үйл ажиллагаанд идэвх санаачилга гарган гадна орчин болон хашаандаа шинээр мод тарьж ургуулсан албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх, иргэдийн дунд болзолт уралдаан зарлан урамшуулж ажиллахыг ажлын хэсгийн нийт бүрэлдэхүүнд даалгасугай.


7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, дүн мэдээг нэгтгэж Засаг даргын зөвлөлд тайлагнаж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Сумъяа)-д даалгасугай.

ДАРГА



Р.БАТЖАРГАЛ

Сумын Засаг даргын 2022 оны 05 сарын 16-ны өдрийн 1/19 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч

Н.Сумъяа

(Засаг даргын орлогч)

Гишүүдэд

С.Ганцэцэг

(Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Т.Эрдэнэцэцэг

(Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

М.Бибиш

(Ерөнхий боловсролын сургуулийн захирал)

Б.Өлзийдүүрэн

(Цэцэрлэгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ц.Цэрэнхүү

(Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Болортуяа

(Соёл, спортын төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ж.Лхагвасүрэн

(Уубулан 1 дүгээр багийн Засаг дарга)

Д.Наранбаатар

(Хүйс 2 дугаар багийн Засаг дарга)

У.Батцэцэг

(Хөнөг 3 дугаар багийн Засаг дарга)

Б.Мөнхбат

(Цагаан ус 4 дүгээр багийн Засаг дарга)

Б.Ганцэцэг

(Бодь 5 дугаар багийн Засаг дарга)

Б.Баяраа

(Бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтэн)

П.Батбаатар

(Байгаль хамгаалагч)

Н.Жаргалсайхан

(Улсын тусгай хамгаалтын байгаль хамгаалагч)

Б.Баяртуяа
(Хаан банкны эрхлэгч)
Г.Долгорсүрэн
(Төрийн банкны эрхлэгч)

_____оОо_____

Сумын Засаг даргын 2022 оны 05 сарын 16-ны өдрийн 15 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралт

“Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагуудын мод тарих хуваарь

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Өөрийн эзэмшлийн газарт	Нийтийн эзэмшлийн газарт	Нийт тарих модны тоо
1	2	3	4	5
Нэг. Албан байгууллагууд				
1	Засаг даргын Тамгын газар	50	500	550
2	Сургууль	500	100	600
3	Эрүүл мэндийн төв	100	200	300
4	Цэцэрлэг	200	100	300
5	Соёлын төв	100	100	200
	ДҮН	950	1000	1950
Хоёр. Аж ахуйн нэгж				
1	ХААН банк	5	30	35
2	Төрийн банк	-	50	50
3	Холбоо	-	5	5
4	Их Богдын ундарга	20	50	70
5	Их Богдын тэргүүн	5	20	25
6	ӨнөрБаянБогд	10	30	40
7	Их хайрхан дэлгүүр	10	5	15
8	Арвижих дэлгүүр	4	10	14
9	АмарБаянБогд цайны газар	6	10	16
10	Нутгийн өгөөж цайны газар	6	10	16
11	“Бэст хонгор” уурын зуух	10	10	20
	ДҮН	76	230	306
	Нийт дүн	1026	1230	2256

оОо

Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд багийн айл өрхийн
тарих модны тоо

№	Багийн нэр	Нийт өрхи йн тоо	Өрхийн тоо				Нийт тарих модны тоо
			Хөдөө амьдар даг өрхийн тоо	1 өрхийн тарих модны тоо	Сумын төвд амьдар даг өрхийн тоо	1 өрхийн тарих модны тоо	
1	2	3	4	5	6	7	8
1	Уубулан 1-р баг	96	94	5	2	10	480
2	Хүйс 2-р баг	155	101	5	54	10	1045
3	Хөнөг 3-р баг	156	130	5	26	10	860
4	Цагаан ус 4-р баг	101	96	5	5	10	530
5	Бодь 5-р баг	134	25	5	109	10	1215
	ДҮН	642	446	-	196	-	4130

_____ оОо _____